

2025 ОНД ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

1. ДЭМБ-ын санхүүжилттэй “Эрүүл мэндийн байгууллагуудын нийгмийн эрүүл мэндийн ажилтныг бэлтгэх, чавахжуулах богино, дунд, урт хугацааны сургалтын хөтөлбөр боловсруулах” ажил

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.9 дэх заалт, МУ-ын Засгийн газар, Глобал сан хооронд байгуулсан ДОХ, Сүрьеэгийн буцалтгүй тусламжийн болон өр хөрвүүлэх хэлэлцээр, МУ-ын Эрүүл мэндийн сайдын “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А132, мөн сайдын 2025 оны А/377 дугаар тушаалын Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах нэгдсэн төлөвлөгөөний дагуу Нийгмийн эрүүл мэндийн байгууллагуудын ажилтныг бэлтгэх ажил явагдаж байна. энэ хүрээнд тэдэнд зориулсан сургалтын хөтөлбөр байхгүй, хоцрогдсон байсан тул шинэчлэн буюу шинээр боловсруулах шаардлага үүссэн.

Иймд Эрүүл мэндийн байгууллагуудын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, ажилтныг бэлтгэх, чадавхжуулах богино, дунд, урт хугацааны чадавхжуулах сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ЭМХТ-ийн захирлын 2025 оны 10 сарын 22-ны А/159 тушаалаар батласан. Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүний нөөцийг харахад НЭМ-ийн чиглэлээр төгсөж мэргэшсэн, нөгөө хэсэг нь нөөц байхгүйгээс ажиллаж байгаа мэргэшээгүй ажилтнууд байна. Иймд нөхцөл шаардлагын дагуу сургалтын хөтөлбөрийг ажилтанд болон мэргэжилтэнд зориулж ДЭМБ-ын 2024 онд нийтэлсэн нийгмийн эрүүл мэндийн үндсэн 12 чиг үүрэгтэй нийцүүлэн 2 төрлийн сургалтын цөм хөтөлбөр боловсруулаад байна. Тус цөм хөтөлбөрийн дагуу Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, мэргэжилтнүүд шинэчилсэн хөтөлбөрийн дагуу мэдлэгээ өргөжүүлж, чадавхжих боломж бүрдээд байна. тус ажил 2025 оны 10 сарын 22-оос эхэлсэн.